



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар Д/142

Хэрлэн сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 2 дугаар хуралдааны 04 тоот тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх “Өндөрхаан тохижилтын газрын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх” ХЭАХЭСЗДТГ/20250102008 дугаар бүхий барааг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г.Лхагвабаатар-Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичиг: Г.Хулан- “Өндөрхаан хот тохижилтын газар”-ын хүний нөөц, Архив, бичиг хэргийн ажилтан
Гишүүд: Л.Ганбаатар- Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалт, үйлчилгээний асуудал хариуцсан ажилтан
Т.Болортуяа-“Өндөрхаан хот тохижилтын газар”-ын нягтлан бодогч
Д.Бямбасүх- “Өндөрхаан хот тохижилтын газар”-ын гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ, нийтийн тээврийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

2.“Өндөрхаан тохижилтын газрын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх” ХЭАХЭСЗДТГ/20250102008 дугаар бүхий барааг гэрээнд заасны дагуу хүлээн авч үр дүнг танилцуулахыг комиссын дарга (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР